

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАЛААЛТЫН
ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ ГҮЙЦЭТГЭЛ
/2019-2020/-д ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ХАЛААЛТЫН ЭЗЛЭХҮҮНИЙГ
БОДИТОЙ ТООЦООГҮЙГЭЭС НЭМЭЛТ ЗАРДАЛ ГАРСАН БАЙНА

АУДИТЫН КОД: БНА-2021/15-4-ШТА-ГА

Баянхонгор хот 2021 он

**Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням

Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Азбаяр

Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn

Аудитор П.Амаржаргал

Утас: 88106996 цахим хуудас: amarjargalp@audit.gov.mn

Аудитор Н.Бүнчинсүрэн

Утас: 99049866 цахим хуудас: bunchinsurenn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.tailan.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	3
Зургийн товъёг	3
Дүрслэлийн товъёг	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
БҮЛЭГ 1. ТҮЛШ ХАЛААЛТЫН ЗАРДЛЫГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРСОН БАРИЛГЫН ХАЛААЛТЫН ЭЗЛЭХҮҮНИЙГ ТООЦООГҮЙ БАЙНА.....	5
1.1. Аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл нь үнэ тогтоох аргачлал, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаагүй нь Эрчим хүчний тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байна.....	5
1.2. Төсөвт байгууллагуудын халаалтын зардлыг төлөвлөхдөө зарим байгууллагын халаалтын хэмжээ, шинээр ашиглалтад орох барилгын халаалтын бодит эзлэхүүнийг тооцоолоогүйгээс төсөвт зохицуулалт хийж нэмэлт зардал гаргасан байна	6
БҮЛЭГ 2. ЗАРИМ ТӨСӨВ БАЙГУУЛЛАГУУД ТҮЛШ ХАЛААЛТЫН ЗАРДЛЫГ ЗАРЦУУЛАХДАА БОДИТ ТОО ХЭМЖЭЭГ ХЯНАХГҮЙ БАЙГААГААС ТӨСВӨӨС ҮРГҮЙ ЗАРДАЛ ГАРЧ БАЙНА	8
2.1. Төсөвт газруудын халаалтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгуулсан боловч зарим аж ахуйн нэгж байгууллага нь гэрээний дүнгээс илүү шилжүүлж төсөвт үрэлгэн хандсан байна	8
2.2. Зарим төсөвт байгууллагуудын халаалтын эзлэхүүний хэмжээ нь гэрээ байгуулсан дүнгээс зөрүүтэй бөгөөд халаалтын чанар муу байна	11
ДҮГНЭЛТ:	14
ЗӨВЛӨМЖ:	15

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
БСШУСС	Боловсрол, шинжлэх ухаан, спортын сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМТ	Эрүүл дэндийн төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Дулааны үнийн судалгаа	5-6
Хүснэгт 2	Халаалтын зардлын 2019, 2020 оны төлөвлөгөө гүйцэтгэл	8
Хүснэгт 3	2020 оны өглөгийн судалгаа	8
Хүснэгт 4	2019 оны халаалтын эзэлхүүний зөрүү	11-12
Хүснэгт 5	2020 оны халаалтын эзэлхүүний зөрүү	12

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Тусгай зөвшөөрөл	5

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Халаалтын зардлын төлөвлөгөө	8
Дүрслэл 2	Аудитад хамрагдсан 53 байгууллагаас халаалтын чанарт өгсөн үнэлгээний судалгаа	13

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны А/27 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийв.
Аудитын зорилт	Аудитын явцад дараах асуудалд гүйцэтгэлийн аудит хийж аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Үүнд: ➤ Түлш халаалтын зардлын төлөвлөлт үндэслэлтэй эсэх ➤ Түлш халаалтын зардлын зарцуулалт үр ашигтай эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс, Эрчим хүчний зохицуулах зөвлөл, аймгийн хэмжээний төсөвт болон төрийн байгууллагууд хамрагдаж тэдгээрийн ажлын төлөвлөгөө тайлан, төсөв, тооцоо барилгын халаалтын эзлэхүүн, төсвийн байгууллагуудын 2019, 2020 онд дулаан хангагч байгууллагатай хийсэн гэрээ, тооцоо нийлсэн акт, санхүүгийн баримт бичиг, үйл ажиллагааны үр дүн, холбогдох бусад материалуудаас авсан мэдээ, тайлан бусад материалд тулгуурлан гүйцэтгэлийн аудитыг хийв.
Аудитын хязгаарлалт	Ковид-19 цар тахал гарч хөл хорио тогтоосонтой холбогдуулан сумдын төсөвт байгууллагыг хамруулаагүй.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүй, Монгол Улсын стандарт-Төрийн аудит MNS6817:2020-ыг ашиглан Дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга авах, санхүүгийн тайлан, объект дээр хэмжилт хийх болон, барилгын зураг, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер А.Цээням аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт тавьж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор П.Амаржаргал, Н.Бүнчинсүрэн нар хөтөлбөр, хуваарийн дагуу гүйцэтгэв. Аудитын төлөвлөгөөг 2021.05.24-ний өдөр батлуулж, талбарын ажлыг 2021.06.02-ны өдрөөс 2021.06.24-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг 2021.06.29-өөс холбогдох үе шатны хяналтаар хянуулан Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, аймгийн ИТХ, Засаг дарга, аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлд хүргүүлэв.
Хүндрэл бэрхшээл	1. Ковид цар тахал гарч зарим шалгагдагч байгууллагын холбогдох албан хаагчид тусгаарлалтад орсон 2. Аудитын багийн гишүүн Ковид-19 өвчний халдвар авч ажлын хуваарь төлөвлөсний дагуу хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн.

БҮЛЭГ 1. ТҮЛШ ХАЛААЛТЫН ЗАРДЛЫГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРСОН БАРИЛГЫН ХАЛААЛТЫН ЭЗЛЭХҮҮНИЙГ ТООЦООГҮЙ БАЙНА

1.1. Аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл нь үнэ тогтоох аргачлал, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаагүй нь Эрчим хүчний тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байна

Баянхонгор сумын хэмжээнд нийт 11 дулаан үйлдвэрлэгч байгууллага төвийн 53 төсөвт байгууллагыг дулаанаар хангаж байгаа бөгөөд энэхүү дулаанаар хангагч байгууллага нь Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т¹ заасны дагуу холбогдох баримт материалыг үндэслэн тусгай зөвшөөрлийг олгосны дагуу үйл ажиллагааг явуулж байна.

Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс олгож буй тусгай зөвшөөрлийг авч Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл²-д заасан 7 төрлийн агуулгыг бүрэн багтаасан эсэхийг авч үзэхэд хуулийн шаардлагыг бүрэн хангасан байна. Зураглал №1 Тусгай зөвшөөрөл



Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөл нь 2019 онд дулаанаар хангагч байгууллагын үнэ тарифыг шинэчлэн тогтоосон байна.

Дулааны үнэ тарифыг тогтооход “инфляцын түвшин харгалзан үзэж үнийг 8 хувиар нэмж тогтоосон” гэсэн тайлбарыг аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс өгөв. Үнэ шинэчлэн тогтоосон байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1. Дулааны үнийн судалгаа

№	Дулаанаар хангагч аж ахуйн нэгж	2019 он		2020 он		Нэмэгдсэн үнэ ₮	Хувиар
		НӨТ-гүй	НӨТ-тэй	НӨТ-гүй	НӨТ-тэй		
1	Рашаант хайрхан ХХК	1500	1650	1620	1782	120	8%
2	RMB ХХК	1550	1705	1670	1837	120	8%
3	Эх бүрдэн ХХК	1550	1705	1670	1837	120	8%
4	Хөвших од ХХК	1560	1716	1680	1848	120	8%
5	ФЮМ ХХК	1500	1650	1620	1782	120	8%
6	Чандмань БХР ХК	1620	1782	1620	1782	0	0%
7	Баялаг дулаан	1700	1870	1700	1870	0	0%
8	Зүүн шанд ХХК	1500	1650	1620	1782	120	8%
9	Марал гүн ХХК	1568	1724.8	1690	1859	122	8%
10	Буянт Аравнай ХХК	1500	1650	1705	1875.5	205	14%
11	Би эйч Энд ди ХХК	1400	1540	1550	1705	150	11%

Гэвч дээрх үнэ тогтоосон байдлаас үзэхэд Эрчим хүчний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2³-д заасан 8 зарчмаас зөвхөн 1 зарчмыг баримтлан бусад

¹ Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

² Тусгай зөвшөөрлийн агуулга

³ Тариф тогтоохдоо дараах зарчмыг баримтална:

зарчмуудыг орхигдуулсан байна. Тухайлбал: Үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурласан байх, цахилгаан, дулааны хангалтад хэрэглэгчдээс тавих шаардлагатай уялдуулан хэрэглэгчийн ангилал тус бүрээр өртөг, зардлыг хуваарилах гэх мэт нөхцөл байдлыг харгалзан үзсэн эсэх нь тодорхойгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөл нь дулаанаар хангагч байгууллагын үнэ тарифыг шинэчлэн тогтоохдоо өртөг тооцох аргачлал, журам мөрдөхгүй байгаа нь Эрчим хүчний тухай хуулийн 11.3.3 -т заасан заалттай нийцэхгүй байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 231 тоот тогтоолоор “Цахилгаан дулааны эрчим хүчний үнэ тариф тогтоох аргачлал”-ыг баталсан бөгөөд уг уг тогтоолд эрчим хүчний зохицуулах хороог үнэ батлуулахыг заасан боловч аймгийн зохицуулах зөвлөл дагаж мөрдөх эсэх талаар тусаагүй байна.

Эрчим хүчний тухай хуулийн 11.3.3-д “Зохицуулах зөвлөлийн баталсан аргачлал...” гэж туссан байгаагаас үзэхэд аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөл нь тусгайлсан аргачлал, журмыг баталж дагаж мөрдөн, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тариф, хэрэглэгчийн үнийг батлахад ашиглахаар заажээ. Гэвч аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөл нь дээрх журам, аргачлал байхгүйгээс өртөг хэрхэн тооцох нь тодорхойгүй байна.

Иймд дээрх журам аргачлалыг дагаж мөрдөх эсэх талаар Эрчим хүчний зохицуулах хорооноос арга зүй зөвлөмж авч, тариф тогтоох аргачлалыг үйл ажиллагаандаа ашиглан дээрх хуулийн заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлд хүргүүлэв.

Эрчим хүчний зохицуулах зөвлөл нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нөхцөл шаардлагыг тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай бүрд нь хяналт хийж ажиллаж байгаа хэдий ч үнэ тариф тогтооход гол үзүүлэлт болох тоо хэмжээний буюу хэрэглэгчийн эзлэхүүний хэмжээнд хяналт хийгээгүй байна. Энэ нь аудитаар төсөвт газруудын эзлэхүүний хэмжээнд хэмжилт хийхэд зөрүүтэй гарч байгаа баримтаар нотлогдож байна. /зорилт 1.2.1-т харуулав/

1.2. Төсөвт байгууллагуудын халаалтын зардлыг төлөвлөхдөө зарим байгууллагын халаалтын хэмжээ, шинээр ашиглалтад орох барилгын халаалтын бодит эзлэхүүнийг тооцоолоогүйгээс төсөвт зохицуулалт хийж нэмэлт зардал гаргасан байна

Аймгийн ТЕЗ-ын харьяаны байгууллагууд төсвийн төслийн боловсруулж аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн төсөв хариуцсан мэргэжилтэнд, босоо тогтолцоотой төсөвт байгууллагууд харьяа дээд шатны байгууллагуудад хүргүүлж байна. Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлсэн аймгийн ТЕЗ-ийн харьяаны байгууллагын 2019, 2020 оны төсвийн төслийн баримтад шаардлагатай мэдээлэл дутуу байгаа нь аудитад хүндрэл учрууллаа.

Аймгийн төвийн төсвийн шууд захирагчийн 2019 онд 29 байгууллага, 2020 онд 34 байгууллагын төсвийн төслийг түүвэрлэн авч үзэхэд дараах зөрчлүүд илэрч байна.

Аудитын илрүүлэлт:

- Байгаль орчин аялал жуулчлалын газар, Баян-ойт цогцолбор сургууль, Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэг, 11 дүгээр цэцэрлэг, 6 дугаар цэцэрлэг, Номундалай цогцолбор сургууль, Онцгой байдлын газар, Нэгдсэн эмнэлэг, Татварын хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуйн газрууд халаалтын эзлэхүүний хэмжээг зөрүүтэй тооцсон.
- Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Асрамжийн газар, Баянхонгор сумын ЗДТГ, 1-р цэцэрлэг, 11 дүгээр цэцэрлэг, 13 дугаар цэцэрлэг, 10 дугаар цэцэрлэг, Онцгой байдлын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Номундалай цогцолбор сургууль, Номгон сургууль, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Эрдэм сургууль, Соого сейко сургууль, Улсын бүртгэлийн хэлтэс гэх мэт байгууллагууд 1м3 эзлэхүүний үнэ тарифыг зөрүүтэй тооцсон
- Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэг, 5 дугаар цэцэрлэг, 6-р цэцэрлэг, 7-р цэцэрлэг, 11-р цэцэрлэг, 13 дугаар цэцэрлэг, Эрдэм сургууль, Улсын бүртгэлийн хэлтсүүд халаах сарын тоог зөрүүтэй тооцсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2."Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх"; гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэст ТЕЗ-ын харьяаны Төсвийн шууд захирагчийн байгууллагын төсвийн төслийг үнэн зөв, хянаж хүлээн авч цаасаар болон цахим архив үүсгэн хадгалах зөвлөмжийг хүргүүлж байна.

2019 онд Түлш халаалтын зардалд Баянхонгор аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хэмжээнд 6,711,443.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас Баянхонгор сумд 2,978,689.3 мянган төгрөг байна.

Харин босоо бүтэцтэй төсөвт байгууллагын хувьд 2019 онд 1,563,810.9 мянган төгрөг батлагдсан байна.



2020 онд Түлш халаалтын зардалд Баянхонгор аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хэмжээнд 7,464,402.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас Баянхонгор сумд 3,473,515.5 мянган төгрөг, босоо бүтэцтэй төсөвт байгууллагын хувь 2019 онд 1,664,456.7 мянган төгрөг батлагдсан байна

Санхүү төрийн сангийн хэлтсээс 2019, 2020 оны халаалтын зардлын төлөвлөлтийг гаргуулан авахад Боловсрол, соёл, хүүхэд хамгаалал анхан шатны эрүүл мэнд, кадастр гэсэн ангиллаар нийт дүнгээрээ гарч байгаа бөгөөд ТШЗ тус бүрээр нь нэгтгэсэн тооцоолол

байхгүй байна. Энэ талаар СТСХ-ийн мэргэжилтнээс тодруулахад “ 2019, 2020 оны төсвийн төслийн тооцооллыг СЯ-ны нэгдсэн сүлжээнд очиж шивдэг байсан, тэр үед нь задгайгаар тооцоолсон судалгааг архивлаагүй, задаргааг гаргах боломжгүй, харин 2021 оны төсвийн шууд захирагчийн төсвийн төслийг архивласан” гэсэн тайлбарыг өгөв.

Иймд цаашид төсвийн төслийн нэгтгэлийг тухай бүрд нь архивын нэгж үүсгэж баримтжуулан архивд хүлээлгэн өгөх зөвлөмжийг өмнөх аудитуудаар аймгийн ЗДТГ-ын СТСХ-т өгсөн байна.

2019 онд Баянхонгор аймгийн Засаг даргын А/645 тоот захирамжаар Төсвийн шууд захирагчийн тогтмол зардалд 205,979.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж зохицуулалт хийснээс 179,472.8 мянган төгрөгийг халаалтын зардалд шилжүүлэн 19 төсөвт байгууллагын өр төлбөрт шилжүүлсэн байна.

Ангилагдаагүй зардалд шилжүүлсэн дээрх өр төлбөр үүссэн шалтгааныг гаргуулан авахад шинээр ашиглалтад орсон барилгын халаалтын зөрүү 124,345.3 мянга, төсвийн төсөвлөлтөд алдаатай тооцоолсноос 55,127.5 мянган төгрөгийн халаалтын зардлыг алдаатай тооцооноос халаалтын зардал нэмэгдэж төсөвт дээрх хэмжээгээр ачаалал үүссэн байна.

Дээрх зардлыг тухайн онд батлагдсан “Утааг бууруулах хөтөлбөр”-т батлагдсан дүнгээс хасаж зохицуулалт хийсэн нь дээрх хөтөлбөрийг хэрэгжих бололцоог алдагдуулсан байна.

Иймд төсвийн зардлыг төлөвлөхдөө бодит тоо хэмжээг, батлагдсан үнэ тарифыг сайтар нягтлан үнэн зөв тооцож байх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтэнд зөвлөв.

БҮЛЭГ 2. ЗАРИМ ТӨСӨВ БАЙГУУЛЛАГУУД ТҮЛШ ХАЛААЛТЫН ЗАРДЛЫГ ЗАРЦУУЛАХДАА БОДИТ ТОО ХЭМЖЭЭГ ХЯНАХГҮЙ БАЙГААГААС ТӨСВӨӨС ҮРГҮЙ ЗАРДАЛ ГАРЧ БАЙНА

2.1. Төсөвт газруудын халаалтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгуулсан боловч зарим аж ахуйн нэгж байгууллага нь гэрээний дүнгээс илүү шилжүүлж төсөвт үрэлгэн хандсан байна

Аудитаар Баянхонгор сумын төвд үйл ажиллагаа явуулж буй 53 төсөвт байгууллагын гэрээг төсөвт байгууллагын 2019, 2020 оны гэрээг авч дүн шинжилгээ хийв. Дээрх 53 төсөвт байгууллага нь аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс батлагдсан үнэ тарифыг бүрэн мөрдөж ажилласан байна.

Төсөвт байгууллагуудын халаалтын үнэ тарифыг 2019 оны 11 дүгээр сард буюу тайлант оны дундуур 1 удаа шинэчлэн баталсан баталсныг төсөвт байгууллага болон дулаанаар хангагч байгууллага нь дараа онд мөрдөж эхэлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.2.5 -д заасан зарчимтай нийцсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг, Политехникийн коллеж, Номундалай ахлах сургууль нь дулаанаар хангагч байгууллагатай гэрээ байгуулахдаа нийт дүгээр гэрээ

байгуулсан ч гэрээнд объект тус бүрийг нь тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 5.1.2 -д заасан зарчимтай нийцэхгүй байна.

Дулаан түгээх “Зүүн шанд”, “ФЮМ”, “RMB”, “Хөвших-Од”, “Эх бүрдэн” ХХК-уудын аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан “Дулаанаар хангах” гэрээнүүдийн удирдлага болгосон хуулийн зүйл, заалтыг хянахад дулаанаар хангагч болон хэрэглэгчийн хооронд үүсэж буй уг харилцаанаас огт өөр харилцааг зохицуулсан хуулийн зүйл заалт болох Иргэний хуулийн 81, 161, 174, 226 гэх зүйл заалтуудыг хэрэглэсэн байгаа нь Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.8 дахь хэсэгт зааснаар гэрээ, хэлцлийн хуулиар тогтоосон хэлбэрийг зөрчсөн байх тул уг гэрээнүүд нь Иргэний хуулийн 56.1 дэх хэсэгт зааснаар хүчин төгөлдөр байдлаа алдах нөхцөл байдалд хүрсэн байна.

Дулаанаар хангагч байгууллагуудтай гэрээ байгуулахдаа гэрээ байгуулж буй үндэслэлийг үнэн зөв, хүчин төгөлдөр хуулийн заалтыг үндэслэлээр авч, гэрээнд тусгах халаалтын эзлэхүүнийг объект тус бүрээр иж бүрэн, үнэн зөв гаргаж байх зөвлөмжийг төсөв захирагч нарт өглөө.

Төрийн сангийн хяналт сул байгаагаас төсөвт байгууллагуудын 2019, 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрч 8,453.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 1,900.9 зөвлөмж болон санхүүгийн тайланд 44,021.7 мянган төгрөгийн залруулга хийсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Өлзийт сумын соёлын төв түлш халаалтын зардлаас ажилтнуудад 660.0 мянга, Өлзийт сумын цэцэрлэг 1,316.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон.
- Дулаан нийлүүлдэг аж ахуйн нэгжээс ирүүлсэн нэхэмжлэхээс илүү Галуут сумын Ерөнхий боловсролын сургууль 928.0 мянга, Галуут сумын ЗДТГ 1,015.5 мянга, Баянхонгор сумын 2-р цэцэрлэг 1,500.0 мянга, Нийгмийн даатгалын хэлтэс 1,734.1 төгрөгийг тус тус шилжүүлж суутган тооцоо хийгээгүй.
- Түлш халаалтын зардлаас Бууцагаан сумын цэцэрлэгийн багш ажилтанд 1,300.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон.
- Политехник коллеж нь 2019 оны санхүүгийн тайланд өглөг тусгаагүй байхад 2020.02.18-ны өдөр “Марал гүн” ХХК-д 44,021.7 мянган төгрөгийг өмнөх онуудын халаалтын үлдэгдэл гэж 2 сарын төлбөр дээр нэмж 85,597.6 мянган төгрөгийн нэхэмжилснийг нэмж шилжүүлсэн тул санхүүгийн тайланд авлагаар залруулсан.

Мөн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар Баянхонгор сумын 6-р цэцэрлэг, Биеийн тамир спортын газрын хөрөнгөнд бүртгэлтэй 2 дугаар баг, 7.9-р баг, 5, 6-р багийн төвүүдийн спорт заалны барилгын халаах эзлэхүүний хэмжээг мэргэжлийн байгууллагаар дахин хэмжүүлэх зөвлөмж өгсний дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газар хэмжилт хийний дүнд өмнөх эзлэхүүний хэмжээ буурч төсөвт хэмнэлт үүссэн байна.

Төсөвт байгууллагуудын халаалтын гэрээг төлсөн мөнгөн дүнтэй тулган шалгахад 2019 онд 1,508.5 төгрөгийг илүү шилжүүлсэн тул төлбөрийн акт тогтоов.

Төсөвт байгууллагууд 2019 онд 8,275,254.8 мянган төгрөгийн түлш халаалтын зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 8,165,873.5 мянган төгрөг зарцуулж 109,381.3

мянга төгрөг хэмнэсэн, 2020 онд 9,128,859.5 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 8,795,277.2 мянган төгрөг зарцуулж 333,582.3 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

Хүснэгт №2: Халаалтын зардлын 2019, 2020 оны төлөвлөгөө гүйцэтгэл /мянган төгрөг/

д/д	Зардлын ангилал	2019 он			2020 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аймгийн ТЕЗ-ын харьяаны байгууллага	6,711,443.9	6,612,377.0	99,066.9	7,464,402.8	7,162,608.2	301,794.6
2	Босоо тогтолцоотой байгууллага	1,563,810.9	1,553,496.5	10,314.4	1,664,456.7	1,632,669.0	31,787.7
	Нийт дүн	8,275,254.8	8,165,873.5	109,381.3	9,128,859.5	8,795,277.2	333,582.3

Монгол улсын Засгийн газраас ковид-19 вируст халдвараас урьдчилан сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан 2020.01.27-ний өдрөөс эхлэн бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалтын үйл ажиллагааг түр зогсоосноос шалтгаалж БСШУСС-ын 2020.04.13-ний өдрийн 1а/2235 дугаар албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.04.22-ний өдрийн А/287 дугаар захирамжаар сургууль цэцэрлэгийн халаалтыг 2020.05.01-ний өдрөөс эхлэн зогсоосон мөн аймгийн төвийн 5 дугаар арван жил ашиглалтад ороогүйтэй холбогдуулан түлш халаалтын зардлаас 108.8 сая зарцуулаагүйтэй холбоотой тус тус хэмнэлт үүссэн байна.

Төсвийн мэргэжилтнүүд дараа жилийн төсвийн төслийг боловсруулахдаа халаалтын эзлэхүүн, тариф, өмнөх оны өр, шинээр ашиглалтад орох барилгын эзлэхүүнийг тооцоолж зардлыг төлөвлөөгүйгээс аймгийн Засаг даргын 2019.12.16-ний өдрийн А/645 тоот захирамжаар тусгай зориулалтын 19 байгууллагын халаалтын зардалд 179.5 сая төгрөгийг ангилагдаагүй зардлаас олгосон байна.

Мөн 2020 онд 56,635.0 мянган төгрөгийн түлш халаалтын өглөгтэй байна

Хүснэгт №3. 2020 оны өглөгийн судалгаа

д/д	Байгууллагын нэр	Өглөг	Тайлбар
1	Баян-Овоо сумын ЗДТГ	14,795.4	Тусгаарлах байр болон халуун усны байр оны дундуур халаалтад холбосонтой холбоотой өр үүссэн
2	Баян-Овоо сумын сургууль	10,763.1	төсөвт хасаж тодотгол хийсэн
3	Баян-Овоо сумын эмнэлэг	3,690.5	төсөвт хасаж тодотгол хийсэн
4	Бууцагаан сумын ЕБС	22,078.5	2020 оны 12 дугаар сард орон нутгийн төсвийн санхүүжилтийг татсантай холбоотой
5	Бөмбөгөр сумын эмнэлэг	1,560.9	Оны сүүлээр буцаж гүйлгээ орж ирсэн
6	Гурванбулаг сумын ЭМТ	1,963.6	нэгдсэн халаалтад 2020 оны 9 сард холбогдсон тул өр үүссэн
	Нийт дүн	54,852.0	

Дээрх хүснэгтээс харахад оны дундуур тодотгол хийгээгүй байхад тусгаарлах байр, халуун ус, цагдаагийн байрыг халаалтад холбогдсонтой холбоотой 14,795.4 мянга, оны эцэст 12 сард халаалтыг зардлыг татсантай холбоотой 38,093.0 мянган

төгрөг, нэгдсэн халаалтад холбогдсонтой холбоотой төсөвт дутуу тооцсон 1,963.6 мянган төгрөгийн тус тус өглөг үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчиж байгаа байгаа тул аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэст өр төлбөр үүсгэхгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

2.2. Зарим төсөвт байгууллагуудын халаалтын эзлэхүүний хэмжээ нь гэрээ байгуулсан дүнгээс зөрүүтэй бөгөөд халаалтын чанар муу байна

Баянхонгор сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй зарим төсөвт байгууллага нь дулаанаар хангагч байгууллагатай “дулаанаар хангах гэрээ”-г байгуулахдаа гэрээнд тусгагдсан эзлэхүүнд хяналт тавьж хэмжилт хийлгэн баталгаажуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалтыг хэрэгжүүлжээ. Тухайлбал:

Аймгийн Политехникийн коллеж, Баянхонгор сумын 1, 6, 9 дүгээр цэцэрлэг, Биеийн тамир спортын газрын харьяа 3-р баг, 5,6-р баг, 7,9 дүгээр багийн төвийн барилга нь мэргэжлийн байгууллагад хандан хэмжилт хийлгэсний үндсэн дээр гэрээнд тусгагдах халаалтын эзлэхүүнийг тодорхойлжээ.

Харин зарим байгууллага нь барилгын зургийг үндэслэн барилгын халаалтын эзлэхүүнийг тодорхойлсон бол зарим байгууллагууд нь дотоодоо хэмжилт хийж гэрээний хэмжээг тодорхойлсон байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар төсөвт байгууллагуудын халаалтын эзлэхүүнд хэмжилт хийн гэрээнд заасан хэмжээтэй тулгалт хийж үзэхэд 2019 онд 325,007.6 мянган төгрөг, 2020 онд 175,817.9 мянган төгрөгийн төлбөрийг төсвөөс илүү төлсөн байгаа нь Аж ахуйн харилцааны дүрмийн 2.2.⁴ д заасан хэмжээг үнэн зөв тогтоогоогүйтэй холбоотой байна.

Хүснэгт № 4. 2019 оны халаалтын эзлэхүүний зөрүү

Төсөвт байгууллагын нэр	Дулаанаар хангагч	Гэрээнд заасан эзлэхүүн	Хэмжилт	Зөрүү	Төлбөр /
Байгаль орчин аялал жуулчлалын газар	"RMB" ХХК	1,033.55	892.81	140.74	1,684.7
Асрамжийн газар	"Эх бүрдэн" ХХК	885	666.83	218.17	1,544.1
Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	"Хөвших од" ХХК	1,257.58	1,329.37	(71.79)	90.9
Биеийн тамир спортын газар /Ягаан зал/	"Эх бүрдэн" ХХК	3,936.8	3,411.94	524.86	447.3
Номгон ахлах сургууль	"ФЮМ" ХХК	4,063	3,600.29	462.71	6,107.7
Эрдэнэмандал сургууль	"Хөвших од" ХХК	21,128.28	19,234.99	1,893.29	25,996.5
Эрдэнэмандал сургууль	"RMB" ХХК	3,635	3,208.04	426.96	5,823.7
Баян Ойт сургууль	Марал гүн ХХК	8,116.8	7,863.75	253.05	1,899.2

⁴ 2.3.Иргэн (айл өрх)-тэй байгуулах дулааны эрчим хүчээр хангах гэрээнд дараах нөхцөлийг тусгана.

2.3.1.дулааны тоо хэмжээ, төрөл;

Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл /2019-2020 он/

Эрдэм сургууль	Марал Гүн ХХК	14,647	12,084.39	2,562.61	30,356.8
9 дүгээр цэцэрлэг	"Хөвших од" ХХК	2,475	1,711.61	763.39	10,847.3
10 дугаар цэцэрлэг	"Эх бүрдэн" ХХК	6,472.8	4,128.20	2,344.60	26,549.8
12 дугаар цэцэрлэг	Марал Гүн ХХК	2,352.36	2,261.99	90.37	1,073.6
15 дугаар цэцэрлэг	"Чандмань-Баянхонгор" ХК	2,280	1,586.59	693.41	4,328.4
Улсын бүртгэлийн хэлтэс	"Эх бүрдэн" ХХК	3,402	3,100.67	301.33	4,578.1
Нэгдсэн эмнэлэг	"Зүүн шанд" ХХК	49,482.8	44,802.05	4,680.75	64,095.9
Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар	"Зүүн шанд" ХХК	4,654	3,966.11	687.89	3,516.5
Баянхонгор аймгийн Татварын хэлтэс	"Эх бүрдэн" ХХК	1,616	1,648.08	(32.08)	510.1
Нийт дүн					189,450.9

Хүснэгт № 5. 2020 оны халаалтын эзлэхүүний зөрүү

Байгууллагын нэр	Дулаанаар хангагч байгууллага	Гэрээний эзлэхүүн	аудитаар	Зөрүү	Төлбөр
Байгаль орчин аялал жуулчлалын газар	"RMB" ХХК	1,033.5	892.81	140.69	1,118.9
Асрамжийн газар	"Эх бүрдэн" ХХК	885	666.83	218.17	839.9
Биеийн тамир спортын газар /Ягаан зал/	"Эх бүрдэн" ХХК	3,936.8	3,411.94	524.86	481.5
Эрдэнэмандал сургууль	"RMB" ХХК	3,635	3,208.04	426.96	1,462.6
Эрдэм сургууль	Марал Гүн ХХК	14,647	12,084.39	2,562.61	7,695.1
3 дугаар цэцэрлэг	"RMB" ХХК	4,017	3,918.09	98.91	1,362.7
5 дугаар цэцэрлэг / төв барилга/	"Эх бүрдэн" ХХК	3,943.3	3,444.26	499.05	12,429.6
6 дугаар цэцэрлэг А байр	"Чандмань- Баянхонгор" ХК	1,561	1,322.18	238.82	2,458.3
9 дүгээр цэцэрлэг	"Хөвших-Од" ХХК	2,475	1,711.61	763.39	10,636.8
10 дугаар цэцэрлэг	"Эх бүрдэн" ХХК	6,472.8	4,128.20	2,344.60	32,383.2
13 дугаар цэцэрлэг	"Чандмань- Баянхонгор" ХК	1,532	1,541.04	(9.04)	3,633.3
15 дугаар цэцэрлэг	"Чандмань- Баянхонгор" ХК	2,280	1,586.59	693.41	13,201.9
16 дугаар цэцэрлэг	Буянт Аравнай ХХК	7,188	7,683.35	(495.35)	362.9
Улсын бүртгэлийн хэлтэс	"Эх бүрдэн" ХХК	3,402	3,100.67	301.33	1,303.8
Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар	"Зүүн шанд" ХХК	4,654	3,966.11	687.89	2,332.3
					91,702.9


Иймд төсөвт байгууллагын халаалтын бодит эзлэхүүнээс илүү гарсан дээрх халаалтын зардлын 281,153.8 мянган төгрөгийн төлбөрийг дулаанаар хангагч байгууллагатай сонсох ажиллагаа хийсэн бөгөөд дээрх хэмжээнд маргаан үүсэж байна.

Мөн аудитын хэмжилтээр бодит эзлэхүүнийг гарган тооцоход дээрх зөрүү нь 500,825.5 мянган төгрөг болохоор байгаа бөгөөд дулаанаар хангагч байгууллага нь мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хэмжилт хийлгэж хэмжээг тогтоолгох хүсэлтэй байгааг илэрхийлсэн болно.

Иймд дулаанаар хангагч байгууллагын хүсэлтийн дагуу халаалтын эзлэхүүнийг Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолоор баталсан "Аж

ахуйн харилцааны дүрэм"-ийн 5.3.4⁵-т заасны дагуу хэмжээг шинэчлэн тогтоолгож, 2022 оны төсвийн төсөлд хийх тооцоонд оруулан, уг хэмжээгээр 2021 оны 09 дүгээр сараас эхлэн төсвийн шууд захирагчдаар мөрдүүлж ажиллах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-т хүргүүлэв.

Аудитад хийх хугацаанд нийт 53 байгууллагын 63 объектыг хамруулан халаалтын чанар, хүртээмж үйлчилгээтэй холбоотой санал гомдлыг холбогдох албан тушаалтнуудтай утсаар холбогдон цахим хэлбэрээр авсан болно.



Нийт судалгаанд хамрагдсан байгууллагуудаас халаалтын чанар сайн-50, дунд-8, муу-5 гэсэн үнэлгээг өгсөн байна. Судалгаанд хамрагдсан байгууллагуудаас БОАЖГ, Асрамжийн төв, Номундалай

ЕБС-ийн хичээлийн шинэ байр, Дөвөнтийн заал, Эрдэм ЕБС, 9-дүгээр цэцэрлэг, 14-р цэцэрлэг, ШШГГ, Татварын хэлтэс зэрэг байгууллагууд халаалтын чанар сайн гэх боловч байгууллагын барилгын дулаан алдагдалтай холбоотой зарим нэг хэсэгт хүйтэн байдаг гэсэн тайлбар өгөв.

Аудитын илрүүлэлт:

Харин Зооноз өвчин судлалын төв, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2 барилга, аймгийн ХХААЖДҮГ нь халаалтын чанар муу гэсэн тайлбарыг өгөв.

Иймд халаалтын чанарт анхаарч дулаанаар хангагч байгууллагад хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлд өгөв.

Аудитаар нийт 681,816.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1,508.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 500,825.5 мянган төгрөгийн албан шаардлага өгч, 179,472.8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

⁵ Аж ахуйн үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдсан барилгад, дулааны тоолуур суурилуулах боломжгүй тохиолдолд халаалтын төлбөрийг эзлэхүүнээр тооцно. Тухайн барилгын халаалтын төлбөр тооцох эзлэхүүнийг өрөөний урт, өргөн, өндөр/давхрын бодит өндөр/-ийн хэмжээгээр тодорхойлно.

ДҮГНЭЛТ:

Шууд тайлагнах аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Баянхонгор сумын хэмжээнд нийт 11 дулаан үйлдвэрлэгч байгууллага төвийн 53 төсөвт байгууллагыг дулаанаар хангаж байгаа бөгөөд энэхүү дулаанаар хангагч байгууллага нь Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасны дагуу тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагааг явуулж байна.
2. Аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл нь үнэ тогтоох аргачлал, журмыг үйл ажиллагаандаа мөрдөөгүй нь Эрчим хүчний тухай хуульд заасан холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байна.
3. Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг, Политехникийн коллеж, Номундалай ахлах сургууль нь дулаанаар хангагч байгууллагатай гэрээ байгуулахдаа нийт дүнгээр гэрээ байгуулсан бөгөөд гэрээнд объект тус бүрийн хэмжээг тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 5.1.2 -д заасан зарчимтай нийцэхгүй байна.
4. Төсөвт байгууллагуудын халаалтын зардлыг төлөвлөхдөө шинээр ашиглалтад орсон барилгын халаалтын эзлэхүүний бодит хэмжээг тооцохгүй байна.
5. ТЭЗ-ийн харьяаны байгууллагын 2019, 2020 оны төсвийн төслийн баримтад халаалтын зардалтай холбоотой шаардлагатай мэдээлэл дутуу, хангалтгүй байна.
6. Төрийн сангийн хяналт сул байгаагаас төсөвт газруудын халаалтын зардлыг зориулалт бусаар зарцуулах зөрчил бүрэн арилахгүй байна.
7. Төсөвт байгууллагуудын гэрээ байгуулсан халаалтын эзлэхүүн нь бодит хэмжээнээс зөрүүтэй байна.
8. Судалгаагаар төсөвт байгууллагын 5 объектод халаалтын чанар муу, 8 объект нь барилгын хийцээс шалтгаалсан дулаан алдалттай байна.

-oOo-

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

НЭГ. ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.БАТСУУРЬ ТАНАА:

1. Эрчим хүчний зохицуулах хорооноос арга зүй зөвлөмж авч, дулааны үнэ тариф тогтоох журам аргачлалыг дагаж мөрдөх, аргачлалыг үйл ажиллагаандаа ашиглан Эрчим хүчний тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах
2. Халаалтын чанар муу байгаа төсөвт байгууллагуудын халаалтын чанарт анхаарч, дулаан алдаж байгаа төсөвт байгууллагуудын дулаан алдагдлыг бууруулах арга зүйн зөвлөгөө өгч, чанар муу халааж буй дулаанаар хангагч байгууллагад хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах.

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН СТСХ-ИЙН ДАРГА С.БАЙГАЛМАА ТАНАА:

1. ТЕЗ-ын харьяаны Төсвийн шууд захирагчийн байгууллагын төсвийн төслийг хянаж хүлээн авч, төсвийн төслийн нэгтгэлийг хүлээн авсан, хянуулсан, баталсан, зохицуулалт хийсэн тухай бүрд нь архивын нэгж үүсгэж баримтжуулан байгууллагын архивд хүлээлгэн өгөх.
2. Төсвийн зардлыг төлөвлөхдөө халаалтын эзлэхүүний бодит тоо хэмжээ, батлагдсан үнэ тарифыг сайтар нягтлан үнэн зөв тооцож байх.
3. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. дахь заалтыг баримтлан өр төлбөр үүсгэхгүй байх.

ГУРАВ. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ДАРГА, ЭРХЛЭГЧ НАРТ:

1. Дулаанаар хангагч байгууллагуудтай гэрээ байгуулахдаа гэрээ байгуулж буй үндэслэлийг үнэн зөв, хүчин төгөлдөр хуулийн заалттай нийцүүлэх, гэрээнд тусгах халаалтын эзлэхүүнийг объект тус бүрээр иж бүрэн гаргаж байх.
2. Дулаанаар хангаж байгууллагатай хийсэн гэрээг оны эцэст дүгнэж тооцоог үнэн зөв нийлэх, халаах хугацаа болон гэрээний дүнд өөрчлөлт орсон тохиолдолд цаг тухай бүрд нь гэрээний өөрчлөлтийг гэрээнд тусган шинэчлэх.
3. Халаалтын чанарын талаар байгууллагын албан хаагчдаас үнэлгээ авах, халаалтын тасалдлыг бүртгэн төсвийн арвилан хэмнэлт, үр ашигтай байдалд хяналт тавих байдлаар Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 11 дүгээр сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.